

УЙГУРЫН ХАР БАЛГАСААС ОЛДСОН НҮҮР ВААРНЫ ТӨРӨЛ, ХЭЭ ЧИМЭГЛЭЛИЙН ТУХАЙ

У.ЭРДЭНЭБАТ¹, Д.СОДНОМЖАМЦ²

¹МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхим, e-mail: u_erdenebat@yahoo.com

²МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхим, e-mail: d.soogii_9@yahoo.com

ТҮЛХҮҮР ҮГС: Монголын археологи, Уйгурын эзэнт гүрэн, нүүдэлчдийн хот суурин, Орхоны хөндий, Хар балгас, барилгын дээврийн чимэглэл, нүүр ваар

ТОВЧ АГУУЛГА: Дорно дахины уран барилгын вааран дээвэр нь орой хэсгийн модон байгууламжийг бороо цас, салхи зэрэг байгалийн хүчин зүйлээс хамгаалахаас гадна дээврийн өнцөг булан, нүүрэн хэсгүүдийг янз бүрийн чимэглэлээр гоёсон өвөрмөц хийцтэй байдаг. Нүүр ваарны хувьд, энэ нь барилгын дээврийн нөмрөг ваарны үзүүр хэсэгт байрлах чимэглэлийн зориулалттай эд бөгөөд хүний нүдэнд ил тусах газар байх тул дээр нь элдэв төрлийн хээ дүрсэлсэн байдаг. Нүүр ваарны хэлбэр дүрс, хээ чимэглэлийг судалснаар тухайн үеийн шашин шүтлэг, соёлын харилцаа хийгээд барилгын үүрэг зориулалт, он цагийн талаарх мэдээллийг гарган авч болно. Энэхүү өгүүлэлд Монголын төв нутаг Орхоны хөндий дэх Уйгурын эзэнт гүрний (744/745-840) нийслэл Ордубалык буюу Хар балгасаас олдсон барилгын дээврийн нүүр ваарыг төрөлжүүлэн ангилж, хээ чимэглэлийг харьцуулан судалсан шинжилгээний урьдчилсан үр дүнгээс нийтэлжээ. Эдгээр нүүр ваар нь бүгд дугуй хэлбэртэй, хэд хэдэн хувилбараар бадамлянхуа цэцгэн хээ дүрсэлсэн бөгөөд ерөнхийдөө бадам цэцгийн дэлбээ ба үр дүрсэлсэн хэмээх хоёр гол төрөл байгаа болно.

744/745 онд уйгурууд хожуу Түрэгийн хаант улсыг даран сөнөөж өнөөгийн Монгол улсын нутгаар төвлөрсөн эзэнт гүрнээ цогцлоон байгуулж 100 гаруй жил оршин тогтнохдоо нэлээд хэмжээгээр хотожсон байна. Архангай аймгийн Хотонт сумын нутагт орших Уйгурын нийслэл Ордубалык буюу Хар балгасын турьд 2009 оноос Монгол-Германы хамтарсан Орхон шинжилгээний анги археологийн хайгуул судалгаа үе шаттай явуулж ирлээ. Хотын зүүн захад орших хааны орд өргөө, шашин мөргөлийн дүүрэг хэмээн судлаачдын таамаглаж буй газар төвлөрөн малтлага хийх явцад барилгын материал, дээврийн ваарны үлдэгдэл нэлээд олдож байна. Хар балгасаас олдсон барилгын дээврийн чимэглэл вааранд бадам цэцгэн хээтэй нүүр ваар, дээврийн тосгуур ваар, нөмрөг ваар, барилгын дээврийн унжсан

нуруу болон салаа нурууны үзүүрийн хэсэгт байрлах зээбадын дүрслэл бүхий дээврийн нурууны толгой ваар зэрэг багтана.

Монгол оронд оршин тогтнож байсан эртний улсууд нь ижил цаг хугацаанд хөрш зэрэгцээ айлсаж байсан Хятадын төрт улсуудтай улс төр, эдийн засаг, соёлын хувьд өргөн харилцаж байсны хувьд аливаа хот суурин, барилга байгууламж барьж байгуулахдаа өмнө зүгийн уран дархчуудын арга технологийг тодорхой хэмжээгээр ашиглан нэвтрүүлсээр иржээ (Дашдорж, 2014: 67). Тангийн (618-907) үеийн уран барилгын хувьд бадам цэцгэн хээтэй нүүр ваар голлон дэлгэрсэн ба домгийн амьтны дүрслэл бүхий зээбад, луу болон бурхны дүрстэй нүүр ваар мөн цөөн тоогоор буй. Бадам цэцгэн хээтэй нүүр ваар нь зөвхөн нийслэл Чан Ань, зүүн нийслэл Лоян хотын малтлагаас олдоод

барахгүй бас нэлээд бөглүү зэлүүд бүс нутагт ч гэсэн тархсан байжээ. Хааны ордон, засаг захиргааны төв, бунхны цэцэрлэгт хүрээлэн, сүм хийд, энгийн иргэдийн оршин сууж байсан байр сууцнаас ч олддог (Chen Lianwei, 2003: 347). Уйгурын нийслэлийн нүүр ваарны лянхуа цэцгэн хээ нь Тан улсын үеийнхтэй төстэй боловч зарим дүрслэлийн хувд ялгаатай, өөрийн гэсэн орон нутгийн онцлогийг тусгасан байна.

Монгол-Германы хамтарсан Орхон хээрийн шинжилгээний ангийн судалгааны баг Хар балгасын зүүн урд хэсэгт байрлах НВ-1 буюу эзэнт гүрний харш/сүмийн хот хэмээн судлаачдын тодорхойлдог гадуураа давхар хэрэмтэй гол хэсэгтээ нэгэн том барилга бүхий цогцолбор байгууламж болон НВ-2 буюу их цайзат хэрмийн дотор талд өндөр шороон цонжны баруун талын барилгын турь зэрэг талбайд 2009-2011 онд, НВ-3 буюу хотын цайзат их хэрмээс баруун урд зүгт, төв гудамжнаас баруун чиглэсэн нэгэн туслах гудамны төгсгөлд байрлах овгор байгууламжийг 2010 онд, цайзат хэрмийн зүүн урд буланд орших Цитадель хэмээх байгууламжийг 2010-2011, 2013-2016 онуудад тус тус малтан шинжлээд байна (Зураг 1).

Хар балгасын нүүр ваарны төрөл

Хар балгасын малтлагаас гарсан олдвор хэрэглэгдэхүүний дотор барилгын дээврийн нүүр ваар багагүй хувийг эзлэх бөгөөд 800 гаруй тоотой олджээ. Эдгээр нүүр ваар нь бүгд дугуй хэлбэртэй, бадам цэцгэн хээг хэд хэдэн хувилбараар дүрсэлсэн байдгаараа бусад үеийнхээс ялгаатай. Хар балгасын НВ-1, 2, 3 болон Цитаделийн малтлагын талбайгаас илэрсэн нүүр ваарнуудыг ерөнхийд нь бадам цэцгийн дэлбээ болон бадам цэцгийн үр дүрсэлсэн хэмээх хоёр төрөл болгон ангилж болно. Үүнээс лянхуан дэлбээ дүрсэлсэн төрөл хамгийн их дэлгэрсэн бөгөөд түүнийг дотор нь 6 хэлбэр, харин бадам цэцгийн үр

дүрсэлсэн төрлийг дотор нь 2 хэлбэр болгон хувааж болохоор байна.

1) Бадам цэцгийн дэлбээ дүрсэлсэн нүүр ваар

Бадам цэцгийн дэлбээн хээтэй нүүр вааран дээр дүрсэлсэн зураг бүтцийн хувьд ихэвчлэн гол хэсэгт буюу дотор талд товгор булцуу, дунд давхрагад лянхуан дэлбээ, гадна давхрагад жижиг үрлэн чимэглэл гэсэн үндсэн 3 хэсгээс бүрдэнэ. Нүүр ваарны гол хэсэгт бадам цэцгийн хонгорцог¹ болон жижиг товгор гэсэн 2 төрөл байна. Дунд хэсэгт дүрсэлсэн дэлбээ нь ихэвчлэн 4, 5, 8, 9 гэсэн тоогоор дугуй болон зууван дугуй хэлбэрийн лянхуан дэлбээг дан эсвэл давхар байдлаар товгойлгон чимэглэнэ. Гурав дахь давхрага буюу гадна талд нүүрэн хэсгийн хөвөө захаар хэлхсэн сувд мэт олон тооны товгор хээг голчлон дүрсэлнэ. Хэсэг бүрийн хоорондох заагаар товгор зурвас хүрээгээр тойруулан заагласан байдаг. Хэмжээ: дунджаар 10-13см голчтой, 1.5-2.5см зузаан байна (Зураг 2).

А хэлбэр: Ваарны гол буюу төв хэсэгт 7 ширхэг үртэй хонгорцгийг дүрсэлсэн ба гадуураа товгор хүрээтэй. Түүний гадна талд зууван дугуй хэлбэрийн 9 ширхэг дэлбээг дүрсэлж дэлбээ бүрийн хооронд гурвалжин хэлбэрийн товгор гаргасан. Гадна талаар нь хэлхсэн сувд мэт олон жижиг бөөрөнхий товгор дүрсээр чимэглэсэн байдаг. Ерөнхий дүрслэлийн хувьд гол хэсгээрээ гадагш бага зэрэг товгор, бүдэг хээтэй. Энэ хэлбэрт хамаарах нүүр ваар Хар балгасын НВ-1 (Зураг 3: 1) болон Цитаделийн малтлагаас олджээ (Зураг 3: 2).

В хэлбэр: Энэ хэлбэрийн нүүр ваар нь дотроо 2 дэд хэлбэртэй.

Ва хэлбэрийн нүүр ваар нь чавганы ясан хэлбэрийн зууван дугуй 4 ширхэг дэлбээтэй ба дэлбээ бүрийн хооронд жижиг бөөрөнхий товгортой. Хонгорцогт 5, эсвэл 7 ширхэг үр дүрсэлсэн байдаг. НВ-1 (Зураг 3: 3) болон НВ-2 (Зураг 3: 4) талбайгаас олджээ.

* Жимс жимсгэнэ, буурцаг мэтийн залаалан сагсайж нэгэн салаанд, шавааралдан ургасан нь:

усан үзмийн хонгорцог, лянхуа цэцгийн хонгорцог (Цэвэл, 1966: 689).

Bb хэлбэр нь ваарны гол хэсэгт 7 ширхэг үртэй хонгорцог, дунд хэсэгт гурван булцуутай дэлбээг дүрсэлсэн ба дэлбээ бүрийн хоёр талаас саран хэлбэрийн дүрсээр хашсан байна. Энэ хэлбэрийн нүүр ваар НВ-2 (Зураг 3: 5) талбай болон Цитаделийн барилгын малтлагаас (Зураг 3: 6) олон тоогоор илэрсэн.

C хэлбэр: Ерөнхий дүрслэлийн хувьд **A** хэлбэрийн нүүр ваартай төстэй боловч гол хэсэгт 8 ширхэг үр бүхий хонгорцогтой, дунд хэсэгт дугуй хэлбэрийн 8 ширхэг бадам цэцгийн дэлбээг дүрсэлснээрээ ялгаатай. Одоогоор зөвхөн Хар балгасын Цитадель дээрх барилгын туриас олдсон болно (Зураг 3: 7).

D хэлбэр: Энэ хэлбэрийн нүүр ваарны хээ өвөрмөц бөгөөд дунд хэсэгт жижиг гурван товгороос бүрдсэн дөрвөн ширхэг дэлбээтэй. Эдгээр дэлбээ бүрийг нуман хэлбэрийн зураасаар гаднах товгор хүрээтэй холбосон. Зарим вааран дээр 8 ширхэг дэлбээг дүрсэлсэн байдаг. Дотор хэсэгтээ бүгд 7 ширхэг үр бүхий хонгорцогтой. 4 дэлбээтэй нүүр ваар Цитаделийн малтлагаас олдсон (Зураг 3: 9) бол 8 дэлбээтэй ваар нь НВ-1 (Зураг 3: 8), НВ-3 (Зураг 3: 10) талбайн малтлагаас олджээ. Мөн энэ хэлбэрт хамаарах боловч хийцийн хувьд болхи, дэлбээнүүдийг хооронд нь холбосон зураас зарим хэсэгтээ байхгүй, дан жижиг бөөрөнхий дэлбээтэй нүүр ваарнууд зөвхөн Цитаделийн малтлагаас олджээ.

E хэлбэр: Нүүр ваар нь гол хэсэгтээ нэг том булцуутай ба түүнийг тойрсон 5 ширхэг зууван дугуй хэлбэрийн дэлбээтэй. Дэлбээ бүрийн хооронд жижиг товгоруудтай ба гадна талаар нь тойруулан хүрээ татжээ. Гадна талд тойруулан олон жижиг товгор гаргасан. Зарим нүүр вааранд гадна талын 2-3 ширхэг товгор хээ бүрийн хооронд босоо зураасан таславч хийж тусгаарласан. Ийм хээтэй ваар НВ-1 (Зураг 3: 11), НВ-3 (Зураг 3: 13) болон Цитаделийн малтлагаас олдсон байна (Зураг 3: 12).

F хэлбэр: Энэ хэлбэрт багтах ваарнууд нь **E** хэлбэрийн нүүр ваартай ижил гол хэсэгт бадам цэцгийн хонгорцог дүрслээгүй, дан ганц товгор булцуутай. Дунд хэсэгт 5 дэлбээг

товгойлгон дүрсэлж дэлбээ бүрийн хооронд таславч босоо зураас татжээ. Дэлбээний гадна талаар үл мэдэх товгор хүрээтэй бөгөөд гаднах хүрээний дотор талд хэлхсэн сувд мэт товгор дүрсээр тойруулан чимэглэж, товгор бүрийн хооронд хашилт хийж тусгаарласан байдаг. Мөн зарим нүүр вааранд ийм хашилт тэмдэг хийгээгүй байна. Ийм хээтэй нүүр ваар Хар балгасын Цитаделийн малтлагаас олон тоогоор гарсан болно (Зураг 3: 14).

G хэлбэр: **E** хэлбэрийн нүүр ваартай ижил боловч ерөнхий дүрслэлийн хувьд гадагш товгор биш. Гол хэсэгт бадам цэцгийн 5 дэлбээг дүрсэлж голд нь нэг ширхэг жижиг товгор гаргасан. Дэлбээний гадна талаар тойруулан товгор хүрээ татаж хэлхсэн сувд мэт жижиг товгор дүрсээр чимэглэсэн. Ийм хэлбэрийн нүүр ваар зөвхөн Цитаделийн малтлагаас олдсон байна (Зураг 3: 15).

2) Бадам цэцгийн үр дүрсэлсэн нүүр ваар

Бадам цэцгийн үр дүрсэлсэн нүүр ваар Хар балгасын малтлагаас цөөнгүй гарсан билээ. Ваарны нүүрэн хэсэгт дүрсэлсэн хээ чимэглэлийн бүтцээс нь хамаараад үндсэн 2 хэлбэрт хуваан үзэж болохоор байна.

A хэлбэр: Нүүр ваарны гол хэсэгт дан товгор хээгээр чимэглэж түүний гадна талаар бадам цэцгийн үрийг 2 эгнээгээр тойруулан чимэглэнэ. Үр бүрийн хооронд болон заагаар ямар нэг товгор зураасан хээ гаргаагүй. Энэ хэлбэрт хамаарах нүүр ваар Хар балгасын Цитадель дээрх барилгын туриас олдсон (Зураг 3: 16).

B хэлбэр: **A** хэлбэрийн нүүр ваарнаас ялгагдах гол онцлог бол гол хэсэгт бадам цэцгийн хонгорцгийг дүрслэн түүний гадна талаар товгор хүрээ татаж гадна хэсгээр тойруулан үрийг дүрсэлсэн байдаг. Ийм хээтэй нүүр ваар Хар балгасын НВ-1 (Зураг 3: 17) болон Цитаделийн малтлагаас олджээ (Зураг 3: 18).

2009-2016 онд Хар балгасын НВ-1, 2, 3 болон Цитаделийн малтлага судалгааны явцад илэрч олдсон нүүр ваарнуудыг хооронд нь харьцуулан үзсэний үндсэн дээр нийт 10 хэлбэрт хуваан үзлээ. Типологи буюу хэв шинжийн судалгааны нэг гол зарчим бол

хэлбэр болон хээ чимэглэлийн хувьд хоорондоо ижил төстэй байгаа олдворууд нь нэг цаг үед нэг газар хийгдсэн байх өндөр магадлалтай байдаг. Хар балгасын дөрвөн өөр талбайгаас илэрсэн эдгээр нүүр ваарнууд цөм бадам цэцгэн хээтэй бөгөөд хээ дүрслэлийн хувьд хоорондоо бага зэргийн ялгаатай байгаа нь тухайн барилгын хөгжлийн түүхийн үе шатыг харуулж байгаа юм. Тухайлбал, нэг барилгад нүүр ваарыг нь энгийн үед 20-30 жил ашигладаг бөгөөд байгалийн хүчин зүйлийн нөлөө болоод өөр ямар нэг шалтгааны улмаас гэмтэж муудах бүр сэлбэн засна. Түүнээс

гадна хотын чухал зарим барилгыг хааны зарлигаар засварлах үед дээврийн чимэглэл нүүр ваарыг нь тодорхой хугацааны дараа сольж шинэчилдэг байжээ.

Бадам цэцгэн хээтэй нүүр ваар нь НВ-1 талбайн малтлагаар 1-р төрлөөс А, Ва, D, E хэлбэрүүд, 2-р төрлөөс В хэлбэр, НВ-2 талбайн малтлагаар 1-р төрлөөс Ва болон Bb хэлбэр, Цитаделийн малтлагаар 1-р төрлөөс А, Bb, C, D, E, F, G хэлбэр, 2-р төрлөөс А, В хэлбэр, НВ-3 талбайн малтлагаар 1-р төрлөөс D, E хэлбэрийн нүүр ваар тус тус олдсон байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Хар балгасаас олдсон бадам цэцгэн хээтэй нүүр ваарны төрөл

Дурсгалын нэр	1-р төрөл								2-р төрөл		Нийт хэлбэр
	A	B		C	D	E	F	G	A	B	
		Ba	Bb								
НВ-1	√	√			√	√				√	5
НВ-2		√	√								2
Цитадель	√		√	√	√	√	√	√	√	√	9
НВ-3					√	√					2

Хар балгасын нүүр ваарны хээ чимэглэлийн тухайд

Хар балгас хотын уран барилгад D болон E хэлбэрийн хээтэй нүүр ваар түлхүү тархсан байна. Мөн НВ-1 барилгаас 5, НВ-2 барилгаас 2, Цитаделиас 9, НВ-3 барилгаас 2 хэлбэрийн нүүр ваарнууд илэрчээ. Үүнээс Цитадель дээрх байгууламжийн турias нүүр ваарны хамгийн олон хэлбэр илэрснийг үзвэл тэнд хэд хэдэн барилга байснаас гадна эдгээр барилгууд олон удаа засварт орсон байж болохыг харуулж байна. Бидний өнгөрсөн жилүүдэд явуулсан малтлагын үр дүнгээс үзвэл Хар балгасын Цитадель дээрээс хэрмийн өндөр ханаар гадуураа хүрээлэгдсэн бат бөх хийцтэй барилгын хана болон баганын боржин чулуун сууриуд олон тоогоор илэрч олдсон юм. Дээрх археологийн цогц байдалд үндэслэн бидний таамаглаж буйгаар бол, энд гол хэсэгтээ дээвэргүй задгай талбай бүхий түүнийг тойрон хүрээлсэн дор хаяж 3-4 тооны барилга байгууламж байсан бололтой байна (Эрдэнэбат нар, 2017: 259). Тухайлбал

Цитаделийн зүүн ханыг дагасан хойд талдаа хаалгатай нэгэн гол барилга, баруун болон хойд ханыг дагасан хоёр барилга байсан ба урд хананы дотор талын талбайд хараахан малтлагын ажил хийгдээгүй байна. Эндээс олдож буй нийт 9 хэлбэрийн нүүр ваарнуудын олдсон газрын байршлаас харвал зүүн, баруун болон хойд талын барилгын турias өөр өөр хэлбэрийн бадам цэцгэн хээтэй нүүр ваарнууд олдож буй нь ихээхэн сонирхолтой. Тухайлбал, зүүн ханыг даган байрласан гол танхимын малтлагаас I төрлийн A, Bb, C, E, F, II төрлийн A, B хэлбэрийн ваарнууд, баруун танхимын гадна болон дотор талын малтлагаас I төрлийн D, C, F, II төрлийн A хэлбэрийн ваарнууд (Зураг 4), баруун болон хойд танхимын дотор талын малтлагаас G, D хэлбэрийн ваарнууд түлхүү олджээ (Зураг 5). Үүнээс I төрлийн Bb, C, F хэлбэрийн нүүр ваарнууд Цитаделийн бүх барилгын турias их бага хэмжээгээр олдсоныг үзвэл эндхийн барилгын үндсэн чимэглэл ваарнууд байсан бололтой. Харин бусад хэлбэрийн нүүр

ваарны хувьд тодорхой төвлөрөлтэй олдож байгаа нь тухайн барилга бүр өөр өөр хэлбэрийн хээ бүхий нүүр ваараар чимэглэгдсэн байсан нь үндсэндээ тодорхой боловч үүний учир шалтгааныг тайлбарлах хангалттай баримт хараахан алга байна. Бусад НВ-1, 2, 3 талбайн нэг барилгаас дор хаяж 2 өөр хэлбэрийн хээтэй нүүр ваар олдож байгаа нь тухайн үед нэг барилгыг олон төрлийн нүүр ваараар чимэглэх уламжлал байсан байж болохыг илтгэнэ. Бидэнд мэдэгдэж буйгаар, Цитаделийн барилгуудын шалны өнгөлгөө тоосго болон ханын дотор талын шаваас зэргийг засаж сэлбэн давхарласан ул мөрүүд нэлээд газар илэрсэн бий. Энэ нь барилгууд хэд хэдэн удаагийн их засварт орж байсны нэг шинж бөгөөд дээвэр хэсгийг засахдаа эвдэрч хагарсан ваарнуудыг нь өөр шинэ ваараар нөхвөрлөн шинэчилж байсныг ч үгүйсгэх аргагүй.

Бадам цэцэг бол Уйгурын үеийн баганын суурь чулуу, хүрэл чимэглэл, бунхны ханын зураг, нүүр ваар зэрэгт хамгийн түгээмэл дүрсэлдэг хээ бөгөөд тухайн үеийн хүмүүс түүний бэлгэдлийн чинад утгыг мэдэж хийж байсан нь гарцаагүй. Тухайлбал, бадам цэцгийн бүрэн дэлбээлж үрээ цацах үеийн байдал нь Хар балгасын II хэлбэрийн нүүр ваарны хээ чимэглэлтэй тун төстэй байгаа тул бид энэ төрлийг бадам цэцгийн үр дүрсэлсэн хэмээн нэрлэж байгаа билээ. Магадгүй, тухайн барилгыг зуны улиралд шинээр барих юмуу сэлбэн засахдаа нүүр вааранд бадам цэцгийн дэлбээ гарсан байдлыг бодолцон мандан бадарч дэлгэрэхийн бэлгэдэл болгон дүрсэлсэн, эсвэл намар цагт бадам цэцэг үр гарсан байдлыг дүрслэн өсөж төлжихийн бэлгэдэл буюу эргээд хавар соёолж гарах зэрэг цаад нарийн утга бэлгэдлийг бодож хийсэн бололтой. Бадам цэцгийг² төвдөөр падма, хятадаар лянхуа (蓮花 -lianhua) хэмээн нэрлэдэг бөгөөд нуурын хөвөө зах хэсгийн тогтуун устай намаг балчиг дунд ургаж цагаан, ягаан, усан цэнхэр өнгийн дэлбээ гаргадаг.

Бадамлянхуа цэцэг нь шавраас төрсөн боловч шаврын хир өчүүхэн ч эс халдсан эрдэмтэй. Түүний дэлбээ нь тоос буртаг өөртөө үл халдаах онцгой чадвартай тул Бурханы сургаалд хорвоогийн муу муухай бүхнийг ялан дийлж цэвэр ариунаар мандан дэлгэрэх дагшин орны бэлгэдэл болгон бурханы мутар, сэнтий суудал болоод уран барилгын чимэглэл болгон дээдэлдэг заншилтай.

Хэдийгээр Цитадель дээрх барилгын туриуд их хэмжээгээр эвдэгдэн тоногдсон боловч нүүр ваар илэрсэн байдал нь тодорхой төвлөрөлтэй, ямар хэлбэрийн ваар аль барилгад хэрэглэж байсан бэ? гэсэн төсөөллийг ямар нэг хэмжээгээр авч болохоор байна. Харин Цитаделийн төв хэсэг хамгийн ихээр эвдэгдэж шал хэсгийн ихэнх тоосгыг хуулж авсан ул мөр нэлээд гарсан бөгөөд эндээс барилгуудын нүүр ваарнууд хоорондоо холилдсон шинжтэй олдворын цогц байдал харагдаж байна. Одоогоор тухайн барилга байгууламжуудын үүрэг зориулалтыг тодорхойлох хангалттай эх хэрэглэгдэхүүн хуримтлагдаагүй боловч малтлагаас олон тоогоор гарсан, хаад ихсэд зориулсан хятад бичигтэй эмгэнэх номын хэсэг зэргээс үзэхэд Уйгурын язгууртан дээдэст зориулсан тахил шүтээний газар байсан байх өндөр магадлалтай байна.

Ямар нэгэн эд өлгийн зүйлийн харьцангуй насыг тогтоох хамгийн тохиромжтой арга бол уг олдворын зүйлийг маш зөв тогтоогдсон типологийн систем дэх өөр нэг зүйлтэй харьцуулах явдал юм (Эрдэнэбат, 2012: 111). Хар балгасаас олдсон нүүр ваарны төрлөөс харахад бүгд хоорондоо ижил төстэй төдийгүй нэгэн цаг үеийн нэгэн соёлд хамаарах нь тодорхой. Уйгурын үед хамаарах бадам цэцгэн хээтэй нүүр ваарын олдворууд Хар балгасаас гадна Монгол улсын Архангай аймгийн Хотонт сумын нутагт орших Өвөр хавцалын амны 3 (Энхтүвшин, Та ла, 2006), 5-р дөрвөлжин (Tala, Chen Yongzhi, 2009), Хундын хоолойн 3-р дөрвөлжин (Очир,

² Энэхүү цэцэг нь манай орны Их нууруудын хотгор, Дархадын хотгор болон Хангай нурууны зарим нуур цөөрөмд ургадаг олон наст ургамал юм.

Эрдэнэболд нар, 2007), Хиргисийн хоолойн 6-р дөрвөлжин (Shanxi daxue, 2016, 36), ОХУ-ын Тувагийн нутагт орших Пор-Бажын хот (Тулуш, 2015: 612, Lyndon et al., 2015) зэрэг газраас олджээ.

Дурдсан газруудаас илэрсэн нүүр ваарнууд нь хээ чимэглэл, дүрслэлийн хувьд Хар балгасын нүүр ваарнуудтай бүх талаараа ижилхэн бөгөөд Хар балгасанд үйлдвэрлэсэн барилгын материалуудыг түүнээс холгүй орших Дөрвөлжин хэмээх бунхант булшны барилга байгууламжид багагүй ашигласан болох нь тодорхой болоод байна. Тухайлбал, Өвөр хавцалын амны 3, 5-р дөрвөлжингөөс олдсон бадам цэцгийн дэлбээ болон үр дүрсэлсэн 2 өөр төрлийн нүүр ваар (Зураг 3: 19, 20, 21, 22) нь Хар балгасын НВ-1, 3 болон Цитаделиас, Хундын хоолойн 3-р дөрвөлжингөөс илэрсэн нүүр ваар (Зураг 3: 23) нь НВ-2 болон Цитаделиас, Хиргисийн хоолойн 6-р дөрвөлжингөөс илэрсэн нүүр ваар (Зураг 3: 24, 25) Цитаделиас олдсон нүүр ваарнуудтай тус тус ижил байгаа юм. Энэ байдлаас үзэхэд, ялангуяа Өвөр хавцалын амны 3, 5 болон Хиргисийн хоолойн 6-р дөрвөлжингүүд Хар балгасын Цитадель дээрх барилгуудтай нэгэн цаг үед хамаарах ба Хундын хоолойн 5-р дөрвөлжингөөс илэрсэн бунхны хананд зурсан бадам цэцгэн хээтэй ижил дүрслэл Хар балгасын НВ-3 болон Цитаделаас илэрсэн нүүр ваартай (D хэлбэр) тун төстэй байна. Мөн Пор-Бажын хотын туриас олдсон нүүр ваарнууд (Зураг 3: 26, 27) нь Хар балгасын НВ-1, 2 болон Цитаделийн нүүр ваарнуудтай ижил байна.

БНХАУ-ын нутагт малтан судалсан Умард Вэй, Сүй, Тан улсын үеийн дурсгалуудаас бадам цэцгэн хээтэй нүүр ваар ихэвчлэн олддог (Li Mei, 2002: 31) бөгөөд хээ чимэглэлийн хувьд Уйгурын үеийн нүүр ваарнаас зарим талаараа бага зэрэг ялгаатай юм. Тангийн эхэн болоод дунд үеийн нүүр вааранд бадам цэцгийн дэлбээг дан болон давхар байдлаар илүү том, нүүрэн хэсэгт дүүргэж дүрсэлдэг онцлогтой (Shen Yunyan, 2006) бол Уйгурын нүүр ваар нь дэлбээг дан байдлаар хооронд нь бага зэргийн зай гарган нэмэлт чимэглэлүүд хийж дүрслэх нь элбэг

байжээ. Хэдийгээр эдгээр ялгаа төдийлөн их биш мэт боловч Хар балгасаас олдсон I төрлийн B, D, E, F болон II A, B хэлбэрийн нүүр ваарнууд нь бусдаас өвөрмөц жинхэнэ орон нутгийн, уйгур хэв маягийн нүүр ваар гэж үзэж болохоор байна.

Монгол нутагт Уйгуруудаас өмнө Түрэгүүд бадам цэцгэн хээтэй нүүр ваарыг бас хэрэглэж байсан бөгөөд Архангай аймгийн Хашаат сумын Хөшөө цайдам дахь Күльтегин жанжин (Зураг 6: 5) болон Билгэ хааны тахилын онгоны (Зураг 6: 4) малтлагаас олон тоогоор олдсон байдаг. Эдгээр бадам цэцгийн дэлбээг дан болон давхар байдлаар дүрсэлсэн Түрэгийн үеийн нүүр ваарнууд нь Уйгурын нүүр ваарнаас арай өөр, харин Тан улсын нийслэл Чан ань хотын Дамин ордон (Зураг 6: 1) (Zhongguo Shehui, 2007), Жүчэн (Зураг 6: 3) ордон (Zhongguo Shehui, 2008: 29/53), зүүн нийслэл Лоян хотын ордны (Зураг 6: 2) малтлагаас (Zhongguo Shehui, 2014: 367) олдсон нүүр ваарнуудтай ижил юм. Энэ нь дурдсан тахилын онгонуудыг барьж байгуулахад Тан улсын эзэн хаанаас тусгай элч илгээн эмгэнэлийн үг хөшөөнд сийлүүлж тахилын сүм барьж байгуулсан хэмээх бичгийн сурвалж тэмдэглэлд гардаг үйл явдалтай (Монгол улсын, 2004: 323) холбоотой билээ. Мөн судлаачдын Түрэг, Уйгур, Хятаны үед хамруулан үзэж буй Хэрмэн дэнжийн балгасаас илэрч олдсон голдоо нэг том товгор бүхий олон жижиг үр дүрсэлсэн бадам цэцгэн хээтэй (Зураг 6: 6) нүүр ваартай (Kradin et al., 2015: 95-103) ижилсэх хэрэглэгдхүүн Уйгурын үеийн дурсгалуудаас одоогоор илэрч олдоогүй байна. Харин энэ ваартай яг ижил нүүр ваар Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт орших Өнгөтийн дурсгалаас олдсон (Зураг 6: 7) бөгөөд магадгүй энэ хоёр дурсгал хоорондоо ямар нэг байдлаар холбоотой байж болохыг цаашид судлаачид анхаарууштай юм.

Нүүр ваар хийх арга ажиллагааны тухай эртний түүхэн сурвалжуудад тэмдэглэн үлдээсэн тоймтой зүйл байдаггүй тул зөвхөн археологийн бодит олдворуудад үндэслэн түүнийг хэрхэн яаж хийсэн талаарх ойлголт авах боломжтой. Уйгурын үеийн нүүр

ваарнууд нь бүгд дугуй хэлбэртэй, нүүрэн талдаа бадам цэцгийг хэд хэдэн төрлөөр чимэглэсэн байх бөгөөд Хар балгасаас олдсон барилгын дээврийн арвин их хэрэглэгдэхүүнээс харахад нүүр ваарыг хэрхэн хийсэн талаарх ул мөрүүд дээр нь нэлээд үлджээ. Бүх нүүр ваарыг бадам цэцгэн хээтэй тусгай хэвэнд цутган хийх бөгөөд хэвнээс гарган авсны дараа ар талд нь нөмрөг ваартай залгагдах хэсэгт хурц үзүүртэй багажаар хэрчин гүн ховил гаргана. Дараа нь

ховил болон нөмрөг ваарны үзүүр хэсэгт нойтон шавар түрхээд хооронд нь барьцалдуулан нааж гадна болон дотор хэсгээс нь нарийн ширхэгтэй шавраар сайтар шавж өө сэвийг засаад хатааж бэхэжсэний дараа зууханд хийж шатаадаг байсан бололтой (Зураг 7). Тийм учраас ихэнх нүүр ваарнууд хагарч унахдаа голоороо тал хэсэг болох эсвэл нөмрөг ваартай залгагдсан яг тэр хэсгээрээ хугарч үлдсэн байна.

НОМ ЗҮЙ

- Дашидорж Б., 2014. Хятаны барилгын нүүр ваарны тухайд (Чинтолгойн жишээн дээр). "Хятаны өв соёл" эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Улаанбаатар.
- Монгол улсын түүх, 2004. Тэргүүн боть (Нэн эртнээс XII зууны дунд үе). Ред. Д.Цэвэндорж. Улаанбаатар.
- Очир А., Эрдэнэболд Л., Одбаатар Ц., Анхбаяр Б., Хатанбаатар Н., 2007. Монгол-БНХАУ-ын хамтарсан археологийн малтлага судалгааны урьдчилсан тайлан. Монголын үндэсний музейн номын сан, Улаанбаатар.
- Тулуш Д.К., 2015. Пор-Бажын –Образец древнекитайской архитектуры в Саяно Алтайском регионе. 中国北方及蒙古, 见加尔, 西伯利亚地区古代文化: 2 册, 内蒙古博物馆, 内蒙古自治区文物考古研究所编, 北京: 科学出版社, 612-617 页。
- Цэвэл Я., 1966. Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар.
- Энхтүвшин Б., Та Ла, 2006. Архангай аймгийн Хотонт сумын нутаг дахь Өвөр Хавцалын амны 3-р дөрвөлжингийн малтлага судалгаа. Монгол улсын нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, Монголын үндэсний музей, БНХАУ-ын ӨМӨЗО-ы соёлын өв, археологи судлалын хүрээлэн. Бээжин. Соёлын өв хэвлэлийн хороо.
- Эрдэнэбат У., 2012. Археологийн үндэс - Судалгааны арга зүй. Улаанбаатар.
- Эрдэнэбат У., Франкен К., Батбаяр Т., Рооланд Х., 2017. Монгол Германы Орхон экспедицийн 2016 оны хээрийн шинжилгээний товч дүнгээс. "Монголын археологи-2016" эрдэм шинжилгээний хурал, Улаанбаатар.
- Kradin N.N., Ivliev A.L., Ochir A., Erdenebold L., Vasiutin S., Satantseva S., Kovychev E.V., 2015. Khermen Denj Town in Mongolia. *The Silk Road*. 13. 95 – 103.
- Arden-Wong L.A., Arzhantseva I.A., Inevatkina O.N., 2015. Reflecting on the Rooftops of the Eastern Uighur Khaganate: A Preliminary Study of Uighur Roof Tiles. *Sino-Platonic Papers*, Number 258, October 2015.
- Chen Lianwei, 2003-, 陈良伟: 《洛阳出土隋唐至北宋瓦当的类型学研究》, 《考古学报》2003 年第 3 期, 347-376 页。
- Li Mei, 2002-, 李梅: 《中原地区莲花纹瓦当的类型与分期》, 《文物春秋》2002 年第 2 期, 31-40 页。
- Shanxi daxue, 2016-, 山西大学历史文化学院、内蒙古文物考古研究所、蒙古国游牧文化研究国际学院: 《蒙古国后杭爱省赫列克斯浩莱山谷 6 号回鹘墓园发掘简报》, 文物, 2016 年第 4 期。
- Shen Yunyan, 2006-, 申云艳: 《中国古代瓦当研究》, 文物出版社, 2006 年 7 月第一版。
- Tala, Chen Yongzhi, 2009-, 塔拉, 陈永志, 宋国栋, 岳够明, 萨仁毕力格: 《蒙古国后杭爱省乌布尔哈布其勒山谷 5 号墓园发掘》, 中国文物报, 2009 年 10 月 23 日。
- Zhongguo Shehui, 2007-, 中国社会科学院考古研究所, 西安市大明宫遗址区改造保护领导小组: 《唐大明宫遗址考古发现与研究》, 文物出版社, 北京。

Zhongguo Shehui, 2008-,中国社会科学院考古研究所:《隋仁寿宫·唐九成宫—考古发掘报告》,北京,科学出版社,2008年,29/53页。

Zhongguo Shehui, 2014-,中国社会科学院考古研究所:《隋唐洛阳城—1959-2001年考古发掘报告》(第二册),北京,文物出版社,2014年,367页。

SUMMARY

THE EAVES TILES OF ROOF FROM KARABALGASUN, CAPITAL OF THE UYGHUR KHAGANAT: TYPE, PATTERN AND DECORATION


U. ERDENEBAAT, D. SODNOMJAMTS

In 744/745 the Uyghurs destroyed Later Turkic Khaganate /Göktürk/ and established their empire in the area of present-day Mongolia. Existing for over 100 years, the Uyghur Khaganat was heavily urbanized empire. Since 2009, Mongolian-German joint Orkhon Expedition (MONDOREx) has conducted archaeological survey and excavation in the ruin of Karabalgasun, settled capital Ordu-Baliq, located in the territory of Khotont soum, Arkhangai province.


During the excavation of the so-called king palace or sacred place in eastern part of the city, masses of building materials and the remains of roof tiles are unearthed: eaves tiles decorated with lotus image, flat tiles, pan tiles and drip tiles with 'zeebad', figure which looks like lion head or gargoyle. Eaves tiles are constructional accessories in front side of roof tiles and fixed at the end of the pan tile. The eaves tiles are figured in many different patterns. Examining eaves tiles' types, shapes and patterns, we found out about the belief, interaction of cultures, building function and the date of artifacts at that time, which was of the great importance for the research.

Ancient states in the area of Mongolia existed in neighbors at same time. Those states were in close political, economic and cultural contact with Chinese dynasties, and borrowed from them some ideas and ways of building construction and walled city. During Tang dynasty, eaves tiles with lotus pattern were very popular in the Chinese architecture. There were few eaves tiles with mythological animal images such as 'zeebad' /gargoyle/, dragon and deity. Eaves tiles with lotus pattern are not only unearthed from excavations in ancient capital Chang'an and the east capital city Luoyang, but they also are unearthed in some remote areas of China. These eaves tiles are found at palaces, administrative centers, tomb parks, monasteries and temples and homes for ordinary people. Although some depictions of the lotus patterns on eaves tiles from Karabalgasun, capital of Uyghur Khaganat are similar to that of the eaves tiles from Tang dynasty, eaves tiles from Karabalgasun have characteristics of local area.




Over 800 pcs of eaves tiles were found during the excavation in Karabalgasun, capital of Uyghur Khaganat. All these eaves tiles are round shaped and patterned with several different types lotus. It is significant that the eaves tiles from Uyghur period are different from that of other periods. The eaves tiles unearthed from excavation areas HB – 1, 2 and 3 can be divided into two types: lotus petal-patterned and lotus seed-patterned, and the most of them were lotus petal-patterned eaves tiles.



Зураг 1. Уйгурын нийслэл Хар балгасын дэвсгэр зурагт Монгол-Германы хамтарсан Орхон экспедицийн малтлага хийсэн газрыг тэмдэглэсэн нь (2009-2016 он)




Зураг 2. Хар балгасын бадам цэцгэн хээтэй нүүр ваарны хээ чимэглэлийн бүтэц


	Хэлбэр		НВ-1	НВ-2	Цитадель	НВ-3	Өвөрханцалын ам 3-р дорволжин	Өвөрханцалын ам 5-р дорволжин	Хундын хоолойн 3-р дорволжин	Хяргист хоолойн 6-р дорволжин	Порбажын хот
I т ө р ө л	A										
	B	Ba									
		Bb									
	C										
	D										
	E										
	F										
	G										
II т ө р ө л	A										
	B										

Зураг 3. Уйгурын үеийн нүүр ваарны төрөл


УЙГУРЫН ХАР БАЛГАСААС ОЛДСОН НҮҮР ВААРНЫ ТӨРӨЛ, ХЭЭ ЧИМЭГЛЭЛИЙН ТУХАЙ



Зураг 4. Хар Балгасын Цитаделийн зүүн барилгын турias илэрсэн нүүр ваарны байршил



Зураг 5. Хар Балгасын Цитаделийн баруун болон хойд барилгын турias илэрсэн нүүр ваарны байршил



Зураг 6. Түрэг болон Тангийн үеийн бадам цэцгэн хээтэй нүүр ваар



Зураг 7. Хар Балгасын нүүр ваарыг хийсэн арга технологи